



“Зорчигч тээвэр дөрөв” ОНӨААТУГ-ын
2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн
01/217 дугаар албан бичгийн хавсралт

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 дугаар тушаалын
7 дугаар хавсралт

“ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ДӨРӨВ” ОНӨААТУГ-ЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН

2025 оны 12 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв (мян төг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
1	2	3	4	5	6	7	8
<p>Зорилт 1. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт: Иргэдийн эрэлт хэрэгцээнд суурилсан үйлчилгээний чанар, хүртээмж, найдвартай байдлыг хангах замаар хувийн авто машины хэрэгцээг багасгаж, нийтийн тээврээр зорчих зорчилтыг нэмэгдүүлнэ. Алсын хараа-2050-9.3, Нийслэлийг хөгжүүлэх 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэл (НХТЖҮЧ)-9.21, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр (НЗДҮАХ)-1.5.1, 1.5.2. Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөө (НХТ-2025)-5.335, 5.337</p>							
1.1	Арга хэмжээ:1.1. Нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг арилгах, оновчтой төлөвлөх саналыг холбогдох байгууллагад хүргүүлнэ. Алсын хараа-2050-9.3.13, НХТЖҮЧ-9.21.1.	-	Нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг бууруулах саналын тоо	1	1	Нийтийн тээврийн бодлогын газарт Ч:7, М:3 чиглэлийн маршрутад өөрчлөлт оруулах санал хүргүүлж, Ч:7А, М:3А чиглэл шинээр нэмэгдүүлэн давхцалыг 7 автобусаар бууруулж, “Таван богдын” автобусны буудлаас эргүүлж өөрчлөлт оруулсан нь үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэв. Мөн чиглэлийн давхцалтай АТ:4 буюу “Нисэх-5 шар-Гандан-ХӨСҮТ” чиглэлийг 2025 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 06/323 дугаартай албан бичгээр зогсоох тухай саналыг тус газарт хүргүүлэв.	100%

1	2	3	4	5	6	7	8
1.2	Арга хэмжээ:1.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. Алсын хараа-2050-9.3.20, НХТЖҮЧ-9.21.2.	-	Чиглэлийн тоо	1	2	Зорчигч урсгалаас хамаарч Х:7 буюу Яармагийн 3-р буудал Туул тосгон чиглэлд эцсийн буудлыг сунгах санал хүргүүлж, Туул тосгон-Хангарди ордон болгож өөрчилөв. Мөн Х:7 чиглэлд 6 тээврийн хэрэгсэл үйлчилж байсныг зорчигчдын хүлээлгийг багасгах зорилгоор гаралтын тоог 2-оор нэмэгдүүлж 8 тээврийн хэрэгслээр үйлчилж байна. Х:6 буюу Өлзийт-Нисэхийн Тойрог-Яармагийн 3-р буудал чиглэлийн эцсийн зогсоолын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах чиглэлээр судалгаа боловсруулж саналыг дээд газарт хүргүүлэв.	100%
1.3	Арга хэмжээ:1.3. Нийтийн тээврийн хэрэгслийн үйлчилгээний чиглэл, сүлжээ, эгнээг оновчтой төлөвлөн эрэлтэд нийцсэн нийтийн тээвэр, зорчих зогсоолыг хөгжүүлэн хүртээмжийг нэмэгдүүлнэ. НЗДҮАХ-1.5.1.	-	Нийтийн тээврийн чиглэл, сүлжээ төлөвлөлтөд өгсөн саналын тоо.	1	2	Сул зогсолт гардаг, авто замын ачааллыг нэмэгдүүлдэг "Хангарди цогцолбор", "Нисэхийн дэнж", "Нисэхийн эцэс"-ийн зогсоолуудад хяналт шалгалтын хуваарь гарган шалгагч нарыг шугам замд тогтмол ажиллуулав.	100%
1.4	Арга хэмжээ:1.4. Нийтийн тээврийн хэрэгслийн дундын болон эцсийн зогсоолын аюулгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх болон удирдлага, хяналтыг дэвшилтэт техник технологи ашиглан сайжруулах, салбарын чадавхыг бэхжүүлнэ. НЗДҮАХ-1.5.2.	-	Нийтийн тээврийн дундын болон эцсийн зогсоолын чанар хүртээмжийг сайжруулах талаар дээд газарт хүргүүлсэн саналын тоо.	-	1	2025 оны 03 дугаар сарын 27-ны өдөр Х:6 чиглэлийн стандарт хангахгүй автобусны эцсийн зогсоолыг зургаар баримтжуулсан судалгааг боловсруулсан. 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Х:7 чиглэлийн автобусны зогсоолын нэршил, координатыг судлан зураг бүхий судалгааг хүргүүлэн зөрүүтэй тэмдэглэгдсэн зогсоолуудыг засварлуулав. 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01/05/142 дугаартай албан бичгээр Ү:31, Ч:79 чиглэлүүдийн эцсийн зогсоолын нөхцөл байдлын талаар дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлсэн.	100%

1	2	3	4	5	6	7	8
						Мөн удирдлага мэдээллийн болон цахим төлбөрийн системд удаан зогссон тээврийн хэрэгслүүдийг онлайн камерын тусламжтайгаар илрүүлж хяналт шалгалтыг тогтмол хэрэгжүүлсэн. Цагдаагийн байгууллагаас 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш нийт 6 албан бичиг ирүүлсэний дагуу бичлэгийг шүүж цахимаар хүргүүлэв.	
1.5	Арга хэмжээ:1.5. Нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлтийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана. Алсын хараа-2050-9.3.11, НХТЖҮЧ-9.22.1	-	Өдөрт үйлчилгээнд гарах тээврийн хэрэгслийн тоо.	105	95	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/274 дүгээр захирамжийн дагуу манай газраас 10 автобусыг хувийн хэвшлийн 2 компанид шилжүүлж захирамжийн хэрэгжилтийг хангуулсан. Парк ашиглалтын коэффициент 97,9 хувьтай.	100%
1.6	Арга хэмжээ 1.6. Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих хүртээмжийг дээшлүүлнэ. НХТЖҮЧ-9.21.3.	-	Арга хэмжээний тоо	-	2	95 автобус нь тэргэнцэртэй иргэдэд үйлчлэх боломжтой байдлаар тоноглогдсон. Байгууллагын зүгээс жолооч нарт тэргэнцэртэй иргэдэд хэрхэн үйлчлэх талаар сургалтыг 2 удаа зохион байгуулав.	100%
1.7	Арга хэмжээ:1.7. Байгууллагын чиг үүргийн хүрээнд үүргийн шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлж, удирдлагын тогтолцоонд реформ хийх ажлыг эхлүүлнэ. НЗДҮАХ-1.5.2, НХТ-2025-5.335	Дотоод эх үүсвэр	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100%	Ажил үүргийн оновчтой хуваарилалт хийж шинэчилсэн бүтцийг захирлын 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдрийн А/94 дүгээр тушаалаар батлуулав.	100%
1.8	Арга хэмжээ:1.8. MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ. НЗДҮАХ-1.5.2, НХТ-2025-5.337	Дотоод эх үүсвэр	Ажлын гүйцэтгэлийн хувь	-	100%	2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 091/2024 дугаартай тохиролын гэрчилгээг авч үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Цаашид MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартыг нэвтрүүлж үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна.	80%

1	2	3	4	5	6	7	8
1.9	Арга хэмжээ:1.9. Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг эхлүүлнэ.	Дотоод эх үүсвэр	Төлөвлөгөө боловсруулсан байна.	-	100%	Дээрх ажлын хүрээнд камерын хяналтын өрөөг 2 компьютер, 8-н дэлгэц холбогдох тоног төхөөрөмжүүдээр тоноглов. Мөн хяналт шалгалтын төлөвлөгөө, журмыг боловсруулж 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр батлуулсан. Дээрх төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтын ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулсан.	100%
1.10	Арга хэмжээ:1.10. Байгууллагын чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Дотоод эх үүсвэр	Төлөвлөгөө боловсруулсан байна.	-	100%	- Эх авалт, оройн буултын зөрчлийн тайлан, нийтийн тээврийн төлбөрийн менежментийн систем"-ийг хэрэглээнд нэвтрүүлэн хэрэгжилтийг нэгтгэн боловсруулж Нийтийн тээврийн бодлогын газарт 7 хоног бүр хүргүүлж ажиллав. - Захирлын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/39 дүгээр тушаалаар Судалгаа, шинжилгээний ажилтны орон тоог баталж байгууллагын статистик тоон мэдээллийг боловсруулах ажлыг зохион байгуулсан.	100%
Зорилт 2. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Нийслэлийн иргэдийн нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэн хөгжүүлж, шуурхай боловсон, ая тухтай үйлчилгээг нэвтрүүлж, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэн, үйлчилгээний менежментийг сайжруулж, нийтийн тээврийн үйлчилгээг олон улсын жишигт хүргэхийг эрмэлзэнэ.							
2.1		-	Шугам цагийн гүйцэтгэлийн хувь	95%	98%	2025 оны байдлаар цагийн гүйцэтгэл бүрэн хангалттай буюу 98.9 хувийн үзүүлэлтэй байна.	100%
2.2	Арга хэмжээ:2.1-2.4. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотойгоор байгуулсан Нийтийн тээврийн бодлогын газартай байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Үйлчилгээний санал гомдлын зөрчлийг бууруулсан тоо	60	30	Жилийн эцсийн байдлаар иргэдээс нийт 29 гомдол ирсэн. Гомдлыг тухай бүр шийдвэрлэсэн.	100%
2.3		-	Шугам замын ашиглалтын саатлыг бууруулсан цаг	53:52	25:00	Ээлжийн инженерүүд шуурхай зохион байгуулалтаар ханган ажилладаг тул ашиглалтын сааталгүй ажилласан.	100%

1	2	3	4	5	6	7	8
2.4		-	Зам тээврийн осол зөрчлийг бууруулсан тоо	16	8	Тээврийн цагдаагийн алба, Нийтийн тээврийн бодлогын газартай хамтарсан сургалтыг 15 удаа зохион байгуулж, үр дүнд зам тээврийн ослын тоо буурч, жолооч нар анхаарал болгоомжтой хөдөлгөөнд оролцох болсон. 2025 онд зам тээврийн осол 2 бүртгэгдсэн.	100%
2.5	Арга хэмжээ:2.5-2.6. Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ. Ангилал ба үйлчилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 5012:2021 стандартын шаардлагыг ханган ажиллах.	-	Хяналт шалгалтын тоо	12	12	Шугам замын хяналтаар ажлын өдрүүдэд хуваарийн дагуу 6 шалгагч ажиллуулсан. Мөн Авто тээврийн хяналтын улсын байцаагч нартай хамтран шугам замын хяналт шалгалтыг зохион байгуулан өгсөн чиглэлийн дагуу холбогдох ажилтнуудыг зорчигчдын хөлс төлөлтөд хяналт тавьж ажиллуулсан. Нийт хяналт шалгалтын тоо: 24	100%
2.6		-	Цэвэрлэгээ, үйлчилгээ хийсэн ажлын чанарын үзүүлэлтийн хувь	100%	100%	Нийслэлийн засаг даргын 133 дугаар захирамжийн дагуу цэвэрлэгээний мэдээг нэгтгэж 7 хоног тутамд, сар бүрийн 30-ны өдөр тайлан мэдээг нэгтгэн дээд газарт хүргүүлж ажиллав.	100%
2.7	Арга хэмжээ:2.7. Авто тээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих ерөнхий шаардлага MNS 4598:2020	-	Техник үйлчилгээ-1, Техник үйлчилгээ-2 үйлчилгээнд хамруулсан хувь	100%	100%	Хуваарийн дагуу техник үйлчилгээ-1, 2 нийт 996 тээврийн хэрэгслийг тус тус хамруулав.	100%
2.8	Арга хэмжээ:2.8. Нийт хөдлөх бүрэлдэхүүнийг улсын үзлэг оношилгоонд бүрэн хамруулах, тээврийн хэрэгслийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг бүрэн хариуцах, нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.	11.7 сая төгрөг /дотоод эх үүсвэр/	Техникийн үзлэг оношилгоонд хамрагдсан автобусны тоо, тээврийн хэрэгслийн ашиглалт	105	105	2025 оны жилийн эцсийн байдлаар DONGFENG, Yutong ZK6116HG, Hyundai HD-72, Hyundai Porter зэрэг нийт 11 тээврийн хэрэгслийг тус тус улсын үзлэг оношилгоонд бүрэн хамруулсан. Yutong ZK6116HG 94 тээврийн хэрэгсэл нь 2024 онд орж ирсэн тул 2026 оны 03 дугаар сард үзлэг оношилгоонд хамруулна.	100%

1	2	3	4	5	6	7	8
2.9	Арга хэмжээ:2.9. Засвар үйлчилгээнд хамрагдсан хөдлөх бүрэлдэхүүний техникийн ерөнхий байдалд тогтмол хяналт тавьж, техникийн бэлэн байдлын коэффициентыг дээшлүүлэн ажиллах.	-	Техникийн бэлэн байдлын үзүүлэлт, хувь	90%	93%	MNS 4601:2011 MNS 5012:2021 стандартад заасан ангилалын дагуу график төлөвлөгөөний хуваарь гарган засвар үйлчилгээний ажлыг тогтмол гүйцэтгэв.	100%
2.10	Арга хэмжээ:2.10. Техникийн саатлыг өмнөх оны үзүүлэлтээс бууруулах техник зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах.	Дотоод эх үүсвэр	Техникийн сааталтай цагийн тоо	120:00 цаг	60:00 цаг	2025 оны жилийн эцсийн байдлаар Техникийн бэлэн байдлын коэффициент 98,9%- тай.	100%
2.11	Арга хэмжээ:2.11. Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг хэрэгжүүлэх, тээврийн хэрэгслийн смартын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	100%	100%	Тээврийн хэрэгслийн GPS-ийн хяналтын системийг өглөөний гаралт, оройн буултаар шалгаж, мөн Улаанбаатар смарт карт ХХК-тай 2024 оны 07 дугаар сарын 20-ны өдөр байгуулсан гэрээний дагуу тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагааг тогтмол хангуулан ажиллав.	100%
Зорилт 3. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт: Хууль тогтоомж, Засгийн газрын болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн гүйцэтгэлийг хангаж ажиллана.							
3.1	Арга хэмжээ:3.1. Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж батлуулна, хэрэгжилтийг хангаж ажиллах	Дотоод эх үүсвэр	Баримт бичиг боловсруулах ажлын явц, хувиар	-	100%	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн засаг даргаар батлуулан хэрэгжилтийг хангуулж байна.	100%
3.2	Арга хэмжээ:3.2. “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	-	95%	Тус хөтөлбөрийн хүрээнд Авлигатай тэмцэх 2025 оны төлөвлөгөө батлуулж хагас жилийн тайланг 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн Засаг Даргын Тамгын газарт хүргүүлж жилийн эцсийн хэрэгжилтийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.	100%
3.3	Арга хэмжээ:3.3. “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр 2024-2030 он” хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	-	95%	2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр Байгууллагын дэргэдэх Ёс зүйн дэд хороог байгуулж үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж албан хаагчдад ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалтыг 3 удаа зохион байгуулав.	100%

1	2	3	4	5	6	7	8
3.4	Арга хэмжээ:3.4. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын хэрэгжилтийг хангаж дээд газарт тайлагнах.	-	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тоо	-	2	Бодлогын баримт бичиг, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг холбогдох журмын дагуу нэгтгэн боловсруулж Нийслэлийн Засаг даргын тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний газарт 2 удаа хүргүүлэв.	100%
3.5	Арга хэмжээ:3.5. Монгол Улсын Засгийн газрын 2011 оны "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" 311, 2018 оны "Төрийн албаны сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан хяналт, шалгалтын тоо	-	2	Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус нийт 17 шалгалтыг зохион байгуулсан. Дээрх төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалтын ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэв. Дотоод хяналт шалгалт Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах ажлын хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 40 ажилтанд сахилгын шийтгэл ногдуулав.	90%
3.6	Арга хэмжээ:3.6. Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс өөрийн байгууллагын хариуцах 27, 47 дугаар индексийн үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан батлуулж хэрэгжилтийг хангах.	-	Хотын хөгжлийн индексийн хэрэгжилтийн хувь	87,4%	90%	Нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, зөрчлийг бууруулах зорилгоор жолооч нарт Нийтийн тээврийн бодлогын газрын даргын 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн А/42 тушаалаар батлагдсан "Удирдлага, мэдээллийн болон цахим төлбөрийн системээр нийтийн тээврийн үйлчилгээний ажлын гүйцэтгэлийг тооцох аргачлал"-ыг танилцуулан үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэв.	100%
3.7	Арга хэмжээ:3.7. Байгууллагын Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	-	90%-иас доошгүй	Дээд газраас ирүүлсэн чиглэлийн дагуу чанарын шаардлага хангасан дизель, цэнхэр түлшийг 2025 оны 02 дугаар сарын 18-ны өдөр тендер сонгон шалгаруулалт зарлаж 2025 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн Т/110 дугаартай гэрээ байгуулж автобуснаас ялгарах хорт утаа, угаарыг бууруулав.	100%

1	2	3	4	5	6	7	8
3.8	Арга хэмжээ:3.8. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, болзошгүй үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан ажлын тоо	2	3	- 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/87, А/88, А/89 тоот тушаалаар Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого судлан бүртгэх журам, орон тооны бус байнгын комисс байгуулав. - Гал унтраах дадлага сургууль зохион байгуулсан. Мөн цайны газрын үйлдвэрлэл, үйлчилгээний эрүүл ахуй, халдвар хамгааллын журам баталсан. - Байгууллагын хэмжээнд эрсдлээс урьдчилан сэргийлж хөдөлмөрийн аюулгүй байдлын “БӨХБАТ АППЛИКЕЙШН”-ыг тогтмол ашигласан. - Ажилтнуудыг үйлдвэрлэлийн осол, гэмтлээс сэргийлж ажлын байранд эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийв.	100%
3.9	Арга хэмжээ:3.9. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээ, тээврийн хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага UCS1603B:2022 стандарт хэрэгжилтийг хангаж ажиллах.	-	Стандарт хэрэгжилтийн хувь	90%	95%	Нийтийн тээврийн үйлчилгээний 14 чиглэлд ажлын өдөр 95, амралтын өдөр 85 автобусаар хэвийн ажиллагааг хангаж, техникийн бэлэн байдлын коэффициент 98,6 хувьтай.	90%
3.10	Арга хэмжээ:3.10. Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, 2025 оны эдийн засгийн үзүүлэлтийг ханган үр ашгийг нэмэгдүүлнэ.	-	Хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100%	100%	Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардал гаргахгүй байхад анхаарч ажилласан. Мөн шинээр ажлын байр бий болгож, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн 3 ажилтны оронд нөхөн томилгоо хийгээгүй, 8 орон тоог царцааж, цалингийн зардлыг хэмнэв. 2025 оны эдийн засгийн үзүүлэлтийг ханган үр ашгийг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	100%
3.11	Арга хэмжээ:3.11. Нийтийн тээврийн бодлогын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр ашиглаж буй нийтийн тээврийн хэрэгслийн машин цагийн	-	Төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн дүн /төгрөг/	3,490.1 3 сая төгрөг	2,617.6 сая төгрөг	2024 оны аудитын зөвлөмжийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2025 оны 07 дугаар	100%

1	2	3	4	5	6	7	8
	зардлын тооцооноос элэгдлийн зардлыг Нийтийн тээврийг хөгжүүлэх санд төвлөрүүлэх.					сарын 01-ний өдөр батлуулан хэрэгжилтийг хангуулж байна.	
3.12	Арга хэмжээ:3.12. Нийтийн тээврийн үйлчилгээний бэлэн мөнгөний орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг ханган орлогыг төвлөрүүлэх.	-	Бэлэн мөнгөний орлогын дүн/төгрөгөөр/	970.2 сая төгрөг	727.7 сая төгрөг	Нийтийн тээврийн үйлчилгээний бэлэн мөнгөний орлого төвлөрүүлэлтэд хяналт тавьж, мөнгөний сангийн аюулгүй байдлыг хангах зорилгоор сейф байршуулсан. Мөн онлайн банкны төлбөр тооцооны хяналтыг сайжруулах зорилгоор сар бүр тооцоо нийлсэн акт гаргаж бэлэн мөнгөний бүртгэлийг өдөр бүр тогтмол хөтлөв.	100%
3.13	Арга хэмжээ:3.13. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулж тайлагнах.	-	Хуулийн хэрэгжилтийн хувь	100%	100%	Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангаж холбогдох гүйлгээ, тайлан мэдээ, тушаал шийдвэрийг стандарт, журмын дагуу шилэн дансны цахим хуудсанд байршуулан ажиллав.	100%
3.14	Арга хэмжээ:3.14. Худалдан авах ажиллагааны батлагдсан төлөвлөгөөний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулах, гэрээ байгуулж хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах.	-	Зохион байгуулсан худалдан авалтын хэрэгжилтийн хувь	90%	95%	2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 25 төсөл арга хэмжээ тусгагдсан. Үүнээс 21-ийг холбогдох хуулийн дагуу тендер сонгон шалгаруулалт зарлаж гэрээ байгуулсан. 4 төсөл нь санхүүгийн болон барилгын ажлын гүйцэтгэлээс шалтгаалан хойшлогдсон. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас эрх шилжиж ирсэн 1 ажлыг хугацаанд зарласан боловч санхүүжилтээс шалтгаалж энэ ажил зогссон.	90%
3.15	Арга хэмжээ:3.15. Албан тушаалын сул орон тоог хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сонгон шалгаруулах зарчмаар нөхөх, ажлын байрны зарыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, вэб сайтаар зарлах, Нийслэл, харьяа дүүргээс зохион байгуулагддаг ажлын байр сурталчлах нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож нээлттэй ажлын	Дотоод эх үүсвэр	Хүний нөөцийн бүрдлийн хувь	90%	95%	Тус ажлын хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр захирлын А/42 тушаалаар хүний нөөцийн сонгон шалгаруулалтын журам батлуулж 115 сул орон тоонд нөхөн томилгоо хийсэн. Мөн Zangia.mn сайттай хамтран ажиллах гэрээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр байгуулж сул орон тоог олон нийтэд нээлттэй зарлан хүний	100%

1	2	3	4	5	6	7	8
	байрыг иргэдэд танилцуулах ажлыг зохион байгуулах.					нөөцийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулав.	
3.16	Арга хэмжээ:3.16. "Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хүрээнд Үйлдвэрчний эвлэлийн хорооны хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	90%	95%	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр батлуулж хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хэрэгжилтийг хангуулав.	100%
Зорилт 4. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт: Байгууллагын үндсэн чиг үүргийн хүрээнд үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангаж, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.							
4.1	Арга хэмжээ:4.1. Байгууллагын цахим хуудсыг төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн хөгжүүлж, аюулгүй байдлыг ханган, байгууллагын үйл ажиллагааг сурталчлах ажлыг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Хэрэгжилтийн хувь	90%	95%	Төрийн байгууллагын Вэб сайтад тавих шаардлагад нийцүүлэн Bus4.ub.gov.mn цахим хаягтай болж байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах ажлыг тогтмол зохион байгуулав.	100%
4.2	Арга хэмжээ:4.2. Нэгдсэн системээр албан байгууллага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх.	-	Шийдвэрлэлтийн хувь	95%	98%	Байгууллагын хэмжээнд нийт 42 өргөдөл, гомдол ирсэн бөгөөд хуулийн хугацаанд шийдвэрлэв.	100%
4.3	Арга хэмжээ:4.3. Албан хэрэг хөтөлөлтийн нэгдсэн системийг холбогдох журмын дагуу хөтөлж, албан бичгийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллах.	-	Шийдвэрлэлтийн хувь	98%	100%	Байгууллагын хэмжээнд нийт 309 аж ахуйн нэгж, байгууллагаас албан бичиг ирж 308 албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэсэн. 1 албан бичиг хуулийн хугацаанд судлагдаж байна.	100%
4.4	Арга хэмжээ:4.4. Байгууллагын архивын сан хөмрөгийн баримтыг Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу бүрдүүлэх, бүртгэх, хадгалах, хамгаалах, иргэд, албан байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу архивын лавлагаа, мэдээллийг олгох, Архивын Улсын үзлэгийн бэлтгэл ажлыг хангах.	-	Архив, албан хэрэг хөтөлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хувь	95%	98%	Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдөр батлуулсан. Баримт бичгийн хуулбарыг нийт 20 ажилтанд хуулбарлан олгосон. Архивын улсын үзлэгт ажлын хэсэг байгуулан төлөвлөгөөний дагуу бэлтгэл хангуулав.	100%
4.5	Арга хэмжээ:4.5. "Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага" MNS6395:2022 стандартын дагуу	-	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Монгол бичгийн хуулийн хэрэгжилтийг хангуулан 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалан,	100%

1	2	3	4	5	6	7	8
	хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтөлж хэвших.					байгууллагаас гарч буй албан бичгийг крилл, монгол хос бичгээр хөтөлж хэвшүүлэв.	
Зорилт 5. Бусад чиг үүргийн хүрээнд.							
5.1	Арга хэмжээ:5.1. Ажилтан, албан хаагчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх, мэргэшүүлэх, харилцаа хандлага, ёс зүй, эрүүл мэндийн чиглэлийн сургалтуудыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	Нийтийн тээврийн бодлогын газар, Замын хөдөлгөөний удирлагын төв, Тээврийн цагдаагийн албатай хамтран сургалт зохион байгуулав.Үүнд: - Нийтийн тээврийн хэрэгсэлүүдэд суурилсан хяналтын камераар ирүүлсэн зөрчил илгээх зөвлөмж сэдэвт сургалт; - Харилцааны ур чадвар хууль эрх зүйн мэдлэг дээшлүүлэх сургалт; - Улаан загалмайн хорооны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал хөтөлбөр газар хөдлөлийн аюулаас сэргийлэх, Галын аюулгүй байдлыг хангах сургалт;	100%
5.2	Арга хэмжээ:5.2. Албан хаагчдын Монгол бичгийн ур чадварыг нэмэгдүүлнэ.	Дотоод эх үүсвэр	Гүйцэтгэлийн хувь	-	100%	Хөгжилд тэмүүлсэн шинэ эрин төрийн бус байгууллагатай хамтран 2025 оны 02 дугаар сарын 10-17-ны өдрүүдэд байгууллагын 52 албан хаагчдад монгол бичгийн сургалт зохион байгуулав.	100%
5.3	Арга хэмжээ:5.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хуулийн дагуу нийт ажилтан, албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, эмчилгээнд хамруулах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	3	Асралт мед, Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлэг, Найрамдал эмнэлэгтэй гэрээ байгуулж эрт илрүүлэгийн оношилгоо шинжилгээнд албан хаагчдыг хуваарийн дагуу бүрэн хамруулсан. Мөн байгууллагын эмч нь өдөр тутмын удьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулав.	100%
5.4	Арга хэмжээ:5.4. Байгууллагын ажилтан, албан хаагчдын дунд биеийн тамир, соёл урлагийн уралдаан тэмцээнийг зохион байгуулах, нийслэл болон систем, байгууллагаас зохион байгуулж буй олон нийтийн арга хэмжээнд хамруулан ажиллах.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	3	Байгууллага болон салбар байгууллагын дунд дараах уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулж амжилттай оролцов. Үүнд: - 2025 оны 05 дугаар сард Байгууллагын аварга шалгаруулах спортын 5 төрөлт тэмцээн;	100%

1	2	3	4	5	6	7	8
						- Автотээврийн салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулсан салбарын аварга шалгаруулах системийн тэмцээн; - Монголын тээвэр холбоо газрын тосны ажилтны үйлдвэрчний эвлэлийн холбоо "ЭВ-НЭГДЭЛ" шилжин явах цомын төлөөх 4 төрөлт тэмцээн;	
5.5	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намрын улиралд мод тарина.	Дотоод эх үүсвэр	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	-	2	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 04, 05 дугаар сард 32 Нарс мод тарьсан. 2025 оны 09, 10 дугаар сард нийт 50 мод тарив.	100%
ДУНДАЖ БИЕЛЭЛТ							98,9

Нийт: 5 зорилтын 47 арга хэмжээ
85-100 хувьтай 46 ажил (бүрэн хангалттай)
70-84.9 хувьтай 1 ажил (хангалттай)
0-69.9 хувьтай ажил (хангалтгүй)

Төлөвлөгөө тайлагнасан:
Зорчигч тээвэр дөрөв ОНӨААТҮГ-ын
Захирал
(албан тушаал)



/Д.Жавхлан/

(огноо)
2025.12.03